

МОНГОЛ УЛСАД ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙГ ТООН СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр” –ийн 5.5.2 дох заалтыг үндэслэн Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системээр дамжуулахад баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлов.

ХОЁР. АШИГЛАХ ДАВТАМЖИЙН ЗУРВАС.

2.1 Монгол Улсад телевизийн нэвтрүүлгийг тоон системээр Хүснэгт 1-д буй радио давтамжийн зурваст дамжуулна.

ХҮСНЭГТ 1.

	Дамжууллын төрөл	Ашиглах давтамжийн зурвас
1	Телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системээр газрын сүлжээгээр дамжуулах	Дециметрийн цараа

2.2 Дэлхийн радио холбооны бага хурал (WRC)-аас гаргасан шийдвэрүүдийг үндэслэн дээрхи давтамжийн зурваст өөрчлөлт оруулж болно.

ГУРАВ. СТАНДАРТ

3.1 Телевизийн нэвтрүүлгийг тоон системээр дамжуулахдаа Хүснэгт 2-т буй олон улсын стандартуудыг мөрдлөг болгоно.

ХҮСНЭГТ 2.

	Дамжууллын төрөл	Монгол улсад мөрдөх стандарт	Олон улсын стандарт	Олон улсын стандарт батлагдсан он
1	Телевизийн өргөн нэвтрүүлгийг газраар дамжуулах	DVB-T2	EN 302 755	2009
2	Телевизийн өргөн нэвтрүүлгийг кабелиар дамжуулах	DVB-C DVB-C2	EN 300 429 EN 302 769	1998 2010
3	Телевизийн өргөн нэвтрүүлгийг хиймэл дагуулаар дамжуулах	DVB-S DVB-S2	EN 300 421 EN 302 307	1997 2009

3.2 Тоон системийн дамжуулалтын стандартыг Хүснэгт 3-т байгаа форматаар хэрэгжүүлнэ.

ХҮСНЭГТ 3.

Телевизийн дэлгэцийн формат /TV Presentation Format/	Дамжууллын стандарт /Transmission Standard/	Студийн гаралт, нягтруулгйн төхөөрөмжийн оролтын хоорондох тоон интерфэйс	Нягтруулгын технологи /Compression Technology/	Нэмэлт үйлчилгээ /Additional Services/
SDTV/HDTV	DVB-T2	SDI HD-SDI	MPEG-4	Дурын байж болно
SDTV/HDTV	DVB-C DVB-C2	SDI HD-SDI	MPEG-2 MPEG-4	Дурын байж болно
SDTV/HDTV	DVB-S DVB-S2	SDI HD-SDI	MPEG-2 MPEG-4	Дурын байж болно

ДӨРӨВ. РАДИО ДАВТАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

4.1 Энэхүү баримт бичгийн 2.1-д заасан давтамжийн зурвасыг ITU-R байгууллагаас гаргасан зөвлөмжинд тулгуурлан Монгол Улсын Үндэсний радио давтамжийн төлөвлөгөөнд Хүснэгт 4-т үзүүлсэн байдлаар тусгана.

ХҮСНЭГТ 4.

Давтамжийн цараа	Радио давтамж төлөвлөлт	Стратеги
Дециметрийн цараанд (UHF)	470-690 МГц	Телевизийн өргөн нэвтрүүлгийг газраар дамжуулах

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

5.1 Монгол Улсад телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системээр дамжуулахдаа дараах байдлаар бүс нутгийн хуваарилалт хийнэ. Үүнд:

5.1.1 Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан байх;

5.1.2 Тухайн хот, суурин газарт телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системээр дамжуулах зэрэг болно.

_____оОо_____